


ХӨСҮТ-ийн 2023 оны 8-р сарын 11-ний өдөр  
албан бичгийн хавсралт



### Гэдэсний халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж

Нэг. Гэдэсний халдварт өвчний ерөнхий мэдээлэл:

2023 оны эхний 5 сарын байдлаар улсын хэмжээнд гэдэсний халдварт өвчний нийт 3819 тохиолдол бүртгэгдэж, 10.000 хүн амд 11.0 байна.

Бүтцээр нь авч үзвэл 80% гар хөл амны өвчин, 13% цусан суулга, 3% хоолны хордлого, 2% сальмонеллэз, 2% суулгалт халдвар тус тус эзлэж байна.

Нийт гэдэсний халдварт өвчний 59.4 хувь нь (n=2267) нийслэл Улаанбаатар хотод, 40.6 хувь нь (n=1552) аймаг орон нутаг тус тус бүртгэгдсэн байна.

2022 оны эхний 5 сард гэдэсний халдварт өвчний 751 тохиолдол бүртгэгдэж 10.000 хүн амд 2.2 ноогдож байсан бол энэ оны эхний 5 сарын байдлаар гэдэсний халдварт өвчний 3819 тохиолдол бүртгэгдэж 10.000 хүн амд 11.0 промилл ногдож байна.

Гэдэсний халдварт өвчин 2023 оны эхний 5 сард:

- гар хөл амны өвчин **3059** тохиолдол буюу 10.000 хүн амд 8.8
- цусан суулга **494** тохиолдол буюу 10.000 хүн амд 1.4
- хоолны хордлого **99** тохиолдол буюу 10.000 хүн амд 0.3
- сальмонеллэз **93** тохиолдол буюу 10.000 хүн амд 0.3
- суулгалт халдвар **74** тохиолдол 10.000 хүн амд 0.2 тус тус бүртгэгдсэн байна.

Говьсүмбэр, Дархан-уул, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Өмнөговь, Төв аймгууд болон нийслэл Улаанбаатар хотын өвчлөл улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна. Иймд гэдэсний халдварт өвчин цаашид ихсэх хандлагатай тул дараах мэргэжил арга зүйн зөвлөмжийг хүргүүлж байна.

Хоёр. Авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний зөвлөмж

А. Эрүүл мэндийн байгууллагуудад:

- Гэдэсний халдварт өвчин голомтлон тархсан үед ЭМС-ын 2018 оны “Зонхилон тохиолдох гэдэсний бактерит халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний заавар” А/528 тоот тушаал, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед ЭМС-ын 2017 оны “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн

хариу арга хэмжээ авах журам" А/328 тоот тушаалыг тус тус мөрдөж ажиллах.

- Сэжигтэй тохиолдлыг анх оношилсон эрүүл мэндийн ажилтан өвчтөнд анхан шатны эрүүл мэндийн тусламж үзүүлэхээс гадна харъяа сум/дүүргийн ЭМТ-д яаралтай мэдээлэх.
- Нэг голомтоос хордлогын шинж тэмдэгтэй 3-аас дээш тохиолдол бүртгэгдсэн үед тушаалын дагуу ХӨСҮТ болон холбогдох байгууллагад 24 цагийн дотор яаралтай мэдээлэх, голомтод эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийж, харъяа дээд шатны байгууллагад эргэн мэдээлэх.
- Мэдээллийг хүлээн авсан халдвар судлагч эмч голомтод тархвар зүйн тандалт судалгаа хийж, холбогдох мэдээ баримтыг цуглуулан, халдварын эх уурхай, өвчин үүссэн шалтгаан, хамрах хүрээ, халдварын тархалтын түвшинг тогтоож, голомтын цар хүрээг цомхотгох хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах дүгнэлт танилцуулгыг ХӨСҮТ болон холбогдох байгууллагад хүргүүлэх.
- Өвчтөн болон сэжигтэй тохиолдлыг тусгаарлаж, сэжигтэй хоол хүнс хэрэглэсэн хавьтагсдыг тандан судлах, илрүүлэх бүртгэх, өвчтөн болон хавьтагсад, орчны эд зүйлсээс нян судлалын шинжлэгдэхүүн авах.
- Сэжигтэй хоол хүнсийг хэрэглэсэн боловч хордлогын шинж тэмдэг илрээгүй тохиолдол, хавьтагсдад нууц үеийн хугацаанд /3-7 хоног/ эмнэл зүйн ажиглалт, хяналт тавих.
- Хүн амын дунд ялангуяа бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх, гарын ариун цэврийн талаар бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг ашиглан сургалт, сурталчилгааг явуулах.
- Өрхийн эмч гэр хорооллын иргэдэд гар угаах, усны савыг хэрхэн угааж цэвэрлэх, усыг хадгалах, энгийн бие засах газар, гэрийн ариун цэвэр, гэрийн ялаатай тэмцэх талаар тогтмол сурталчилгаа хийх.
- Дэвсгэр нутгийн хүн амын ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдалд тандалт хийж, шаардлагатай бол Засаг захиргаа, хяналтын байгууллагуудад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

#### **Б. Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд дараах зөвлөмжийг зөвлөж байна**

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар жил бүр 220 сая хүүхэд суулгалт өвчинд өртөж, 96 000 нь нас бардаг. Манай улсад урин дулааны улиралд гэдэсний халдварт өвчин дэгдэж, уг өвчнөөр 0-4 насны хүүхдүүд илүүтэй өвчилж байна. Гэдэсний халдварт өвчин халуурах, бөөлжих, цустай, залхагтай шингэнээр олон удаа суулгах, гэдэс базлах, өвдөх, хий дүлүүлэх шинж тэмдгээр илэрдэг.

Бага насны хүүхдийг гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэхийн тулд эцэг, эхчүүд болон хүүхдийг асран хамгаалагч нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Бага насны хүүхэд халуурсан, бөөлжсөн, шингэнээр суулгасан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд яаралтай эмч, эмнэлгийн байгууллагад хандах,



- Эхийн сүү нь суулгалт халдвар болон бусад халдвараас хамгаалах, хүүхдийн дархлааг дэмждэг тул нярай хүүхдээ эхийн сүүгээр хооллох,
- Бага насны хүүхдыг тусдаа аяга, халбага, угжтай байлгах, тэдгээрийг халуун бүлээн усаар сайтар угааж, цэвэр байлгах, тусад нь хадгалах,
- Хүүхдийн хоол тэжээлийг бэлтгэх, хүүхдээ хооллохын өмнө гараа сайтар савандаж угаах, хүүхдийн хоол, тэжээлийг бэлтгэх орчноо байнга цэвэр байлгах,
- Хүүхдийг бие зассаны дараа гараа угаах дадалд сургаж хэвшүүлэх,
- Шууд хэрэглэх жимс, хүнсний ногоог халуун бүлээн цэвэр усаар сайтар угааж хэрэглэх,
- Ил задгай, зөвшөөрөгдөөгүй цэгээс баталгаагүй хүнсний бүтээгдхүүнийг худалдан авахгүй байх, ил задгай булаг шандны ус уухгүй байх,
- Эцэг, эхчүүд, хүүхэд асран хамгаалагчид бие зассаны дараа, бохирдсон тухай бүр нь гараа тогтмол угааж хэвших
- Хүүхдийн тоглоомыг савантай халуун, бүлээн усаар угааж, цэвэр газар хадгалах,
- Гэртээ угаалга цэвэрлэгээг тогтмол хийх, гадуур өмсдөг гутал, хувцсаа сольж байх.

## **В. Нийт ард иргэдэд дараах зөвлөмжийг зөвлөж байна.**

Манай улсад урин дулааны улиралд гэдэсний халдварт өвчин, хоолны хордлогот халдвар, олон хүнийг хамарсан дэгдэлтүүд бүртгэгддэг. Гэдэсний халдварт өвчнөөр бүх насны хүмүүс өртөх боловч эрсдэлт бүлэг болох бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан, архаг суурь өвчтэй хүмүүс илүү хүнд өвчилдөг тул нийт иргэдэд дараах урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

1. **Хоол хүнсээр дамжих өвчнөөс хэрхэн сэргийлэх вэ?**
  - Хоол, хүнсийг бүрэн чанаж болгож хэрэглэх
  - Чанаж, болгосон хоолыг удаан хадгалахгүй байх
  - Хоол бэлтгэхийн өмнө гараа сайтар савандаж угаах
  - Түүхий болон болсон бүтээгдэхүүнийг тус тусад нь хадгалах
  - Түргэн мууддаг хүнсний бүтээгдэхүүнийг хөргөгчинд хадгалах
  - Шинэ жимс, ногоог хүнсэнд хэрэглэх, хэрэглэхийн өмнө сайтар угаах
  - Хоносон хоол, удаан хадгалсан хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй байх
2. **Усыг хэрхэн хэрэглэх вэ?**
  - Ундны усыг буцалгаж хэрэглэх
  - Зориулалтын саванд усаа хадгалах
  - Ундны усыг цэвэр саванд авч, 24 цагийн дотор хэрэглэх
  - Усны саваа өдөр бүр угааж хэвших

### 3. Гараа хэзээ угаах вэ?

- Гэдэсний халдварт өвчний үүсгэгч нь хүний нүдэнд харагдахгүй, тааны бохир гар дээр өсөж үржин дамжин тархдаг тул гарын ар, хумсны хэсэг, гарын салааг оролцуулан бүлээн усаар сайтар савандаж угаах
- Хоол, хүнс бэлтгэхийн өмнө угаах
- Өөрөө болон хүүхдээ хооллохын өмнө
- Гар бохирлогдсон тохиолдол бүрт угаах
- Бие зассаны дараа, хүүхдийн өтгөнийг цэвэрлэсний дараа угаах
- Бактерийн эсрэг гарын саванг өргөн хэрэглэх



### 4. Өвчин үүсгэгч нян хаана илүүтэй байдаг вэ?

- Гэдэсний халдварт өвчин үүсгэгч нян нь халдварт өвчтэй хүн болон эрүүл нян тээгчийн өтгөнөөр гадагшилж гадаад орчныг бохирдуулдаг. Хөрсөнд 3-5 сар, усанд 2сар, хоол хүнсэнд 2-60 хоног, ялгадасд 2-4 жил амьдрах чадвартай.
- Salmonella-түүхий сүү, өндөг, тахианы маханд их өсч үрждэг
- Shigella-цөцгий, махан хоол, ногоо, жимсэнд их үрждэг
- Bacillus cereus-буруу хадгалсан цагаан будаа, үр тариа
- Clostridium perfringens-шувууны мах, урьдчилан чанасан хоол
- Staphylococcus-урьдчилан чанасан хоол, мах
- E.coli-дутуу болгосон үхрийн мах, түүхий сүү, ногоо, жимс зэрэгт өсч үрждэг.

### 5. Хоол хүнсний бүтээгдэхүүнд нян үржихээс хэрхэн сэргийлэх вэ?

- Хоол хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай тавихгүй байх
- Халуун орчинд удаан хадгалахгүй байх
- Шошгод заасан хугацааг баримтлах, хөргөгчид хадгалах
- Болсон болон түүхий хүнсийг тус тусад нь хадгалах, хэрчих,
- Зориулалтын саванд усаа хадгалах, өдөр тутам угааж цэвэрлэх,
- Ундны усны эх үүсвэрийн орчимд бие засах, усанд орох, хувцас, эд зүйлсийг угаахгүй байх
- Гэдэсний халдварт өвчний нянг зөөвөрлөгч нь ялаа тул түүнээс сэргийлж тор татах, устгах
- Энгийн бие засах газар, бохирын цооног, хогийн цэгийг халдваргүйжүүлэх

**ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**